



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А1475

Улаанбаатар хот

Барилга байгууламж данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02/24 дугаар, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2018 оны 01 дүгээр, 2020 оны 05, 22 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Зүүн нарангийн 5-22 тоотод байрлах 30,912,742.23 /гучин сая есөн зуун арван хоёр мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хорооны хуучин барилгыг хувьчилсан тул данс бүртгэлээс хасахыг Ерөнхий нягтлан бодогч Н.Уранчимэгт зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ